

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Үндэслэл

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц, Монгол Улсын Хүүхэд Хамгааллын тухай хуулийн “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”-ын 6 дугаар бүлэгт заасны дагуу хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалагдах эрхтэй.

Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”-ын 6.1 дэх хэсэгт “Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж ажиллана” гэж заасны дагуу суралцагч бүрийг сургуулийн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого нь багш, ажилтан, албан хаагчдын ойлголт, хандлага, зан үйлд нөлөөлөх, хүүхдийг хүндэтгэсэн, хүүхдэд итгэл үзүүлсэн, үнэт зүйлийг хөгжүүлэхэд чиглэсэн байгууллагын дотоод үйл ажиллагаа бөгөөд хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахыг нотолсон баримт бичиг юм. Сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтан, сайн дурын идэвхтэн болон бусад холбогдох хүмүүсийн хийж, хэрэгжүүлэх ажлыг тодорхой тусгана.

Хоёр. Зорилго

2.1. Эцэг эх, хамтарсан баг, иргэний нийгэм, салбар, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар сургуулийн суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэх, үл хайхрах байдал, аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, сургуулийн орчинд суралцагчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдэнэ.

Гурав. Зорилт

- 3.1. Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах;
- 3.2. Хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;
- 3.3. Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр багш нартай хамтран ажиллах;
- 3.4. Хүүхдийн эрүүл мэнд, эсэн мэнд амьдрах орчин нөхцөлийг сайжруулах төсөл хөтөлбөр боловсруулан ажиллах;
- 3.5. Хүүхэд хамгааллын чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн ажиллах;
- 3.6. Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хөгжүүлэх.

Дөрөв. Баримтлах зарчим

- 4.1. Суралцагч нэг бүрийг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж, тэдний аюулгүй байдлыг хангах;
- 4.2. Хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртсөн, өртөж болзошгүй талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн бол мэдээллийг хүлээн авах, сургуулийн орчинд хүчирхийлэл, эрсдэлд өртсөн суралцагч болон мэдээлэгчийн нууцыг чанд хадгалах;
- 4.3. Сургуульд хүчирхийлэл болон аливаа болзошгүй эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хянах, үнэлэхэд оролцогч талууд тэгш, идэвхтэй хамтын ажиллагаа, оролцоог эрхэмлэх;
- 4.4. Суралцагчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцуулахгүй байх.

Тав. Хамрах хүрээ

- 5.1. Энэхүү бодлого нь байгууллагын үндсэн болон гэрээт бүх багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид хамаарна.

Зургаа. Үйл ажиллагааны чиглэл

6.1. Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах

- 6.1.1. Сургуулийн хүүхэд хамгааллын баг байгуулах;
- 6.1.2. Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, сургуулийн орчныг аюулгүй бүс болгох;
- 6.1.3. Хүүхдийг сургуульдаа ирэх, буцах замын аюулгүй байдлыг судалж, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх;
- 6.1.4. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- 6.1.5. Сургуулийн орчныг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаар тохижуулах, үнэлгээ хийж сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулах;
- 6.1.6. Хүүхдэд байгалийн гамшиг, онцгой байдлын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт сургах сургалт зохион байгуулах.

6.2. Хүүхдийн эрхийг хамгаалах, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

- 6.2.1. Хүүхэдтэй шууд ба шууд бус харьцан ажиллах удирдах ажилтан, сайн дурын идэвхтний мөрдөх “Хүүхэд хамгааллын ёс зүй”-н дүрмийг боловсруулах;
- 6.2.2. Суралцагч нэг бүрийн эрсдэлийн судалгааг гарган мэдээллийн сан бүрдүүлэх;
- 6.2.3. Насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой гэмт хэрэг дээр ажилладаг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, цагдаа нартай хамтран ажиллах;
- 6.2.4. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн конвенцийн талаар сургалт зохион байгуулах;

- 6.2.5. Гэмт хэргийн хохирогч болсон, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;
- 6.2.6. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн, хохирол учрахуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийг аюулаас зайлуулах арга хэмжээг нэн тэргүүнд авч ажиллах.
- Хэрэв тухайн асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол:
 - ✓ Хууль цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэж, хэргийг шилжүүлнэ. Гэмт хэрэг мөн эсэхийг зөвхөн хууль, цагдаагийн байгууллага тогтооно. Мөн тухайн харьяа хүүхэд хамгааллын байгууллагад давхар мэдэгдэнэ.
 - Хэрэв тухайн асуудал нь гэмт хэргийн шинжгүй бол:
 - ✓ Буруутай этгээдийн асуудлыг сургуулийн дотоод дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.
 - ✓ Хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой байгууллага, харьяа хүүхэд хамгааллын байгууллага болон мэргэжлийн байгууллагад холбон зуучилна.

6.3. Хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр багш нартай хамтран ажиллах

- 6.3.1. Сонгон, секц, дугуйлангийн тоо, төрлийг нэмэгдүүлэх;
- 6.3.2. Сонгон, секц, дугуйланд хамрагдах суралцагчийн тоог нэмэгдүүлэх, нөхцөл боломжоор ханган ажиллах;
- 6.3.3. Сонгон, секц, дугуйлангийн чанар, үр дүнд хяналт тавих, үр дүнгийн судалгаа, тайлан хийх;
- 6.3.4. Урлаг, спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулах, суралцагчийг шагнаж урамшуулах;
- 6.3.5. Суралцагчийн авъяасыг нээн хөгжүүлэх, тайлан үзэсгэлэн гаргах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- 6.3.6. Суралцагчийн суралцаж буй мэргэжлийн чиглэлээр үйлдвэртэй танилцах аялал, дадлага, сургалт зохион байгуулах;
- 6.3.7. Суралцагчийн соёл хүмүүжил, ёс зүйн төлөвшил, танин мэдэхүйн хөгжилд чиглэсэн лекц, семинар, сургалт зохион байгуулах.

6.4. Хүүхдийн эрүүл мэндийн талаар

- 6.4.1. Сургуулиас суралцагчийг хичээлийн жилд 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэгт оруулан, эрүүлжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;
- 6.4.2. Суралцагчийг улсаас зохион байгуулж байгаа эрүүл мэндийн үзлэг, вакцинд хамруулах;
- 6.4.3. Гэр бүл, хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, эрүүл өсгөж хүмүүжүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчийг мэдээллээр хангах;
- 6.4.4. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй орчныг дэмжсэн төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, оролцох;

- 6.4.5. Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчид сургалт, сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулах;
- 6.4.6. “Нөхөн үржихүйн боловсрол” олгох чиглэлээр ТББ-ын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах.

6.5. Оюутны зөвлөлийн чадавхийг сайжруулах, суралцагчийн өсвөр үеийн оролцоог нэмэгдүүлэх талаар

- 6.5.1. МКТК-ийн оюутны зөвлөлийн үйл ажиллагааг чадваржуулах, мэдээ мэдээллээр хангах;
- 6.5.2. Суралцагчдын дунд зохион байгуулагдах уралдаан наадам, тэмцээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэн, бусдаасаа суралцах нөхцөлийг бүрдүүлнэ;
- 6.5.3. Суралцагч бүрт хүрч, арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангаж ажиллах;
- 6.5.4. Секц дугуйлан, клубийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тогтмол зохион байгуулах;
- 6.5.5. Суралцагчийн уран бүтээлийг дэмжин, бүтээлийн үзэсгэлэн гаргах;
- 6.5.6. Дотоод болон гадаадын уралдаан, тэмцээнд амжилт гаргасан хүүхдүүдийг тогтмол дэмжин урамшуулах;
- 6.5.7. Оюутны зөвлөл, суралцагчийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг чиглүүлэн дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах.

Долоо. Удирдлага, зохион байгуулалт

- 7.1 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн байдал, сургуулийн орчинд гарсан хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээ, тайланг тогтмол хугацаанд нэгтгэж, МКТК-ийн захирлын дэргэдэх зөвлөл болон шаардлагатай төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.
- 7.2 Сургуулийн захирал нь сургууль дээрх хүүхэд хамгааллын асуудлыг хариуцах бөгөөд сургуулийн оюутны алба, нийгмийн ажилтан, ангийн зөвлөх багш, эмч нарын төлөөллөөс бүрдсэн хүүхэд хамгааллын багтай хамтран зохион байгуулна. Энэхүү баг нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.
- 7.3 Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийг сургуулийн жилийн төсөвт тусган, зохих үйл ажиллагаанд зарцуулж, тайланг хагас жил тутам гаргана /Хуулийн хүрээнд/.
- 7.4 Сургуулийн орчинд хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх ажилд хяналт тавина.
- 7.5 Сургуулийн үйл ажиллагааны онцлог, хэрэгцээнд тулгуурлан хүүхдийн нас бие, танин мэдэхүйд тохирсон хүүхэд хамгаалал, хүүхдийг уламжлалт болон эерэг аргаар хүмүүжүүлэх, хүчирхийлэл, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, сургуулийн удирдлага, багш, ажилтныг сургаж, мэдээллээр хангах

- 7.6 Сургуулийн захирал нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж, холбогдох мэдээллийг дээд шатны боловсролын байгууллагад мэдээлнэ.

Найм. Хяналт үнэлгээ

- 8.1. Сургуулийн орчны эрсдэлийн үнэлгээг сургуулийн захирал, нийгмийн ажилтан, оюутны зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн баг хийх бөгөөд хүүхдийг болзошгүй эрсдэлд хүргэх өндөр эрсдэлтэй үйл ажиллагааны жагсаалтыг гарган эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авч, хэрэгжүүлэх.

Ес. Хүрэх үр дүн

Сургуульд хүүхдийн сурч, амьдрах эрүүл, аюулгүй хамгаалагдсан орчин бүрдэнэ.

- 9.1 Хүүхэд, эцэг эх, багш нар хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн ойлголттой болсноор бусдын ялгаатай байдлыг ойлгосон, хүүхдийг хүндэтгэсэн, хамгаалсан, зүй бус хандлагыг үл тэвчсэн, хохирлыг арилгасан нийгэм сэтгэлзүйн таатай орчин бүрдсэн байна.
- 9.2 Эцэг эх, иргэд, олон нийт сургуулийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцсоноор хүүхдийн өмнө хүлээх хариуцлага сайжирч, эрүүл, аюулгүй, эрсдэлээс хамгаалагдсан, сургалтын үйл ажиллагаанд тэгш хамруулсан, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээг авах боломж нэмэгдэнэ.

**“Монгол Коосэн” Технологийн коллежийн Хүүхэд хамгааллын бодлогын
хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөө**

№	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага
1. Урьдчилан сэргийлэх					
1.	Захирлын тушаалаар Сургуулийн хүүхэд хамгааллын багийг байгуулах	XI сард	Багш, ажилтан, Эцэг эх	Чанарын нэгж	ОА, СА,
2.	Эмзэг бүлэг, эрсдэл бүлгийн судалгааг гаргах	XII сард	Бүх оюутан	Оюутны алба	
3.	Хүүхэдтэй шууд ба шууд бус харьцан ажиллах удирдах ажилтан, багш, ажилчин, сайн дурын идэвхтний мөрдөх Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг боловсруулж, баталгаажуулан хөдөлмөрийн гэрээнд хавсаргах	XII сард	Удирдах ажилтан, багш, ажилтан, сайн дурын идэвхтэн	Оюутны алба	
4.	“Төлөвшлийн төлөө хамтдаа” аян өрнүүлэх	Хичээлийн жилд	9-12-р анги		
5.	“Ном бол ертөнцийг харах цонх мөн” аян өрнүүлж, хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэн, төлөвшүүлэх	I сард	Бүх оюутан	Номын санч, монгол хэлний багш нар	Төрийн болон төрийн бус байгууллага.
6.	Хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулж хэвших	Хичээлийн жилд	9-12 анги	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	Төрийн болон төрийн бус байгууллага.

7.	“Цахим орчны зөв зохистой хэрэглээ” сургалт, илтгэл, хэлэлцүүлгийг зохион байгуулах	Хичээлийн жилд	9-12 анги	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	Төрийн болон төрийн бус байгууллага
8.	Эцэг эх, оюутан, багшийн гурвалсан уулзалт	11, 3-р сар	Оюутан, эцэг эх, багш, ажилтан	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	
9.	Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал сургалт зохион байгуулах	III сард	9-12-р анги		
2. Эрсдэлийг бууруулах					
10.	Сургуулийн гадна дотно орчинд учирч болзошгүй эрсдэлийг тооцож, аюулгүй орчин бүрдүүлэх.	Хичээлийн жилд	9-12 анги	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	Сургуулийн захиргаа, Эцэг эхийн зөвлөл
11.	Сургуулийн орчны аюулгүйн зураглал гаргах /галын аюул, байгалийн гамшгийн үед орох гарах гарцын зураг/	X сард	Сургуулийн орчин	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	
3. Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах					
12.	Сургуулийн орчинд хамгаалал шаардлагатай хүүхдийн мэдээллийг сургуулийн хүүхэд хамгааллын багт өгөх маягтыг байршуулах	Хичээлийн жилд	Багш, ажилтан, эцэг эх, олон нийт	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	
13.	Хүүхэд хамгааллын зөрчлийн талаар мэдээлэл авах хайрцаг ажиллуулах		Багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагчид	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	Оюутны алба
4. Хариу үйлчилгээ үзүүлэх					
14.	Анги танхим, хонгил, сургуулийн гадна талын гэрэлтүүлэг, камерт хяналт тавих		9-12 анги	Сургуулийн хүүхэд хамгааллын баг	

15.	Хүүхдийн эрүүл мэндийн асуудалд хяналт тавих	Хичээлийн жилд	9-12 анги	Сургуулийн эмч	Оюутны алба
16.	Уралдаан, тэмцээн, арга хэмжээг өндөр зохион байгуулалттай, аюулгүй зохион байгуулах		9-12 анги	Сургуулийн Хүүхэд хамгааллын баг	
17.	Эрсдэлийн зэрэг өндөртэй буюу эрсдэлд орсон сурагчдыг мэргэжлийн байгууллагатай холбон зуучлах		9-12 анги	Сургуулийн Хүүхэд хамгааллын баг	

Төлөвлөгөө боловсруулсан: Оюутны албаны менежер

/Г.Өлзийнаран/